



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/1513

Чингис хот

Аймгийн онцгой комиссын
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдах үүрэг бүхий аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, хавсралтаар баталсугай.

2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулж, хяналт тавих арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн, онцгой комисс ажиллах журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд онцгой комиссын орлогч дарга /Ц.Чогсомжав/, Онцгой байдлын газрын дарга бөгөөд онцгой комиссын орлогч дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/414 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010903

Аймгийн Засаг даргын 2020 оны
 11... дугаар сарын 11... өдрийн А/513
 дугаар захирамжийн хавсралт

Д/д	Комиссын бүрэлдэхүүн	Албан тушаалтан
1	Комиссын орлогч дарга	Аймгийн Засаг даргын орлогч
2		Онцгой байдлын газрын дарга
3		Комиссын нарийн бичгийн дарга
4	Гишүүд	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга
5		Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
6		Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
7		Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
8		Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
9		Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
10		Цэргийн штабын дарга
11		Нийгмийн бодлогийн хэлтсийн дарга
12		Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудтын хэлтсийн дарга
13		Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
14		Эрүүл мэндийн газрын дарга
15		Цагдаагийн газрын дарга
16		Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний Хэнтий Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга
17		Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ны ЗӨБСалбарын Өндөрхаан дэд станцын дарга
18		Мэргэжлийн хяналтын газрын дарга
19		Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
20		Авто тээврийн үндэсний төвийн Хэнтий аймаг дахь салбарын дарга
21		Зам засвар арчлалтын "Харгуй" компаний захирал
22		Тагнуулын хэлтсийн дарга
23		Байгаль орчны газрын дарга
24		Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга
25		Нийтийн ахуйн үйлчилгээний "Хэнтий ус" ХХК-ийн захирал
26		Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
27		"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ний салбарын захирал
28	Улаан загалмайн хорооны дарга	
29	Холбооны газрын дарга	
30	Мал эмнэлгийн газрын дарга	
		Зооноз өвчин судлалын төвийн дарга